



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 4/44

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн биеийн тамир,  
спортын хороодын ажилтан, албан хаагчдын  
тэмцээнийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын ажилтан, албан хаагчдын тэмцээнийг 2017 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Багануур дүүргийн БТСХорооны спорт зааланд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 700.000 /Долоон зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Б.Түвшинбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын  
2017 оны 09-р сарын 18-ны өдрийн  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын  
ажилтан, албан хаагчдын тэмцээнийг  
зохион байгуулах төсөв

| №    | Зардлын нэр                                                                                                          | Нийт дүн<br>/төг/ |
|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| 1.   | Тамирчдын шагнал:<br>1 x 160.000 төг = 160.000 төг<br>1 x 140.000 төг = 140.000 төг<br>1 x 100.000 төг = 100.000 төг | 400.000           |
| 2.   | Шүүгчдийн ажлын зардал<br>7 хүн x 2 өдөр x 20.000<br>1 хүн x 1 өдөр x 20.000                                         | 300.000           |
| ДҮН: |                                                                                                                      | 700.000           |

Боловсруулсан  
Хянасан

Б.Түвшинбаяр  
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны даргын  
2017 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодын  
ажилтан, албан хаагчдын тэмцээний шүүгчдийн  
бүрэлдэхүүн

- |                  |              |
|------------------|--------------|
| 1. Ерөнхий шүүгч | Б.Түвшинбаяр |
| 2. Шүүгч         | М.Гантөмөр   |
| 3. Шүүгч         | Ю.Батсайхан  |
| 4. Шүүгч         | Б.Мөнхбаяр   |
| 5. Шүүгч         | Г.Тэмүүлэн   |
| 6. Шүүгч         | Д.Энхбаяр    |
| 7. Шүүгч         | Ж.Болдбаатар |
| 8. Шүүгч         | Б.Баттөр     |